



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.03.24 № 3/551
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу "Шинжлэх ухаан технологийн их сургууль"-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан нь үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

- Төсөл, хөтөлбөртэй холбоотой томилолтын зардлыг 9,599.0 мянган төгрөгөөр илүү тооцсон.
- Төслийн урьдчилгаа санхүүжилт болох 40,630.2 мянган төгрөгийг шууд орлогоор хүлээн зөвшөөрч эрдэм шинжилгээний гэрээт ажлын орлого дансанд бүртгэсэн. Энэ нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга-д заасан "жинхэнэ хэрэгжилтийн зарчим"-ийг хэрэгжүүлээгүй.

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн дагуу бараа материалын зарцуулалтыг байгууллагын нярав цаг тухайд нь бүрэн гүйцэд хөтлөөгүй, жилийн эцсийн бараа материалын тооллогыг ерөнхий нягтлан бодогч зохиох заавар журмын дагуу үнэн зөв, бодитой хэрэгжүүлээгүйгээс 2015 онд шаардах хуудсаар зарцуулсан 23,797.3 мянган төгрөгийн бараа материалыг өмнөх үеийн үр дүнд залруулах бичилт хийсэн.
- 2015 онд 59,140.3 мянган төгрөгийн барилгын дээвэр засвар хийлгэсэн боловч авлагаар бүртгэсэн. Энэ нь НББОУС 16.7 "Дараах шалгуурууд нэгэн зэрэг биелэгдсэн үед үндсэн хөрөнгөөр бүртгэнэ. Үүнд: а) аж ахуйн нэгжид ирээдүйн эдийн засгийн үр өгөөж авчрах боломжтой байх, б) хөрөнгийн өртгийг үнэн зөв хэмжих боломжтой байх" болсон үед үндсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрч бүртгэх ёстой байсныг зөрчсөн.
- Русский мир байгууллагаас 4 удаагийн гүйлгээгээр 21,374.6 мянган төгрөг дансаар орсныг байгууллагад өгөх өглөгөөр бүртгээд, дэмжих баримтгүйгээр 21,308.6 мянган төгрөгийг Русский центрт зохион байгуулах хурлын зардал гэсэн гүйлгээний утгатай мөнгөн хөрөнгийн зарлагын баримтаар өглөгийг хаасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн.
- Мөнгөний нярав 2016 оны 1 дүгээр улиралд 4 оюутны тушаасан 3,002.7 мянган төгрөгийг кассад орлого аваагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.6 заалтыг зөрчсөн.
- Сургалтын төлбөрийн тооцоо, төлөлтийг санхүүгийн алба, сургалтын алба хоёр тус тусдаа хийдэг ба харилцан мэдээлэл солилцох нэгдсэн журам тогтоогүйн улмаас ШУТИС-ын харьяа 11 сургууль дээр санхүү, сургалтын албаны авлага, урьдчилж орсон орлогын данс зөрсөн ба нийт 154,940.0 мянган төгрөгөөр ШУТИС-ийн нэгтгэсэн тайлангийн өмнөх үеийн үр дүнг нэмэгдүүлэх зарлуулах бичилт хийсэн байна.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн болно гэдэгт итгэлтэй байна.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Дээр дурдсан алдаа, зөрчлийн санхүүгийн тайланд үзүүлж болзошгүй нөлөөллийг эс тооцвол Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу дагуу материаллаг зүйлийн хувьд үнэн шудрага илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг
хүсвэл дараах хаягаар
харилцана уу:**

**САГ-ын дарга, тэргүүлэх
аудитор:** Ц. Наранчимэг
Утас: 261663
Цахим
хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер:
Я.Самбууням
Утас: 260512
Цахим
хаяг: sambuunyamya@audit.gov.mn

Ахлах аудитор: Н. Батсайхан
Утас: 260512
Цахим
хаяг: batsaikhann@audit.gov.mn

**ТАБ-ын хаяг: ЗГ-ын IY байр
Бага тойруу 6 Улаанбаатар -
46
Цахим хуудас:**

“СМД” ХХК-ийн

**Аудитын багийн ахлагч
Д.Гэндэнпэлжээ**
Утас: 99172936,
Аудитын менежер:
Б.Жаргал
Ахлах аудитор: Я.Чойжилсүрэн
Аудиторын туслах: Б.
Мөнхцацрал
Утас: 99110699, 99175995

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4-р
хороо, Хүнсний 1-н ард 12/5
байр 7 дугаар

Вэб хуудас: www.cmdaudit.mn

Аудитын тайлан

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Менежментийн захидал

Хавсралт 3: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 4: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг түвшин
6. Дотоод хяналт
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /САГ-2017/324/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Шинжлэх ухаан технологийн их сургуульнь санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн Сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2016 оны 09 дүгээр сарын 28-наас 2017 оны 3 дугаар сарын 15-ныг хүртэл хийхээр төлөвлөн аудитын багийн гишүүнээр “СМД Аудит” ХХК-ийн захирал, аудитын багийн ахлагч Д.Гэндэнпэлжээ, Чанарын хяналтын менежер Б.Жаргал нар удирдан зохион байгуулж, “СМД Аудит” ХХК-ийн Ахлах аудитор Я.Чойжилсүрэн, Аудитор А.Одонзул, Аудиторын туслах Б.Мөнхцацрал, Б.Мөнхцог, Б.Уламбаяр, Н.Сувдаа нар хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Шинжлэх ухаан технологийн их сургууль байгууллагын 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 02 дүгээр сарын 25-нд “СМД Аудит” ХХК-д ирүүлсэн байна.

“СМД Аудит” ХХК 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөлтийг 2016 оны 10 дугаар сарын 24-нөөс 12 сарын 12-ны хооронд, завсрын аудитыг 2016 оны 10 дугаар сарын 10 -нд эхэлж, 2017 оны 01 дугаар сарын 25-нд дуусгасан ба завсрын аудитад 20 салбар сургууль, алба хэлтсийн 2016 оны эхний 9 сарын байдлаар санхүүгийн баримтуудыг хамруулсан. Харин жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 02 дүгээр сарын 25-наас 2017 оны 03 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 03 дугаар сарын 25-нд Шинжлэх ухаан технологийн их сургуулийн удирдлагад гардуулсан болно.

2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Шинжлэх ухаан технологийн их сургуульнь 2011 оны 12 дүгээр сарын 23-ны өдөр батлагдсан “Төсвийн тухай хууль”, 1996 оны 05 дугаар сарын 27-ны өдөр батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хууль, 2001 оны 12 дугаар сарын 13-ны өдөр

батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хууль, 1994 оны 5 дугаар сарын 31-ны өдөр батлагдсан “Нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын тухай” хууль, 2002 оны 06 дугаар сарын 28-ны өдөр батлагдсан “Төрийн албаны тухай”, 2011 оны 12 дугаар сарын 23-ны өдөр нэмэлт оруулсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай”, 1999 оны 5 дугаар сарын 14-ны өдөр батлагдсан “Хөдөлмөрийн тухай” хууль, 2012 оны 12 дугаар сарын 27-ны өдөр батлагдсан Сангийн Сайдын 290 тоот тушаал, 2006 оны 11 дугаар сарын 27-ны өдөр батлагдсан Сангийн Сайдын 388 тоот тушаал зэрэг хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Байгууллагань "Мэргэжлийн өндөр мэдлэг, дадал, чадавхтай, бүтээлч сэтгэлгээтэй мэргэжилтэн, судлаачдыг бэлтгэх; нийгмийн түншлэл, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаанд тулгуурлан эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг бизнес, инновацийн үйл ажиллагаанд нэвтрүүлэх" эрхэм зорилгыг тавин ажиллаж байна.

Дээрх зорилгыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18-д “Төсвийн бусад байгууллагын дарга тухайн байгууллагын төсвийн захирагч байна” гаж заасны дагуу Шинжлэх ухаан технологийн их сургуулийн ректор нь Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2016 оны сургуулиудын төсвийн үйл ажиллагааны тогтмол зардлыг Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам болон Хөдөлмөрийн Яамны төрийн сангаас олгож, сургалтын төлбөрөөр бусад үйл ажиллагааны зардлуудыг бүрдүүлж байна.

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан болно.

4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс Шинжлэх ухаан технологийн их сургуулийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансанд түүвэрчилсэн байдлаар аудитын 9 чиглэлээр 48 хяналтын горим, 3 нарийвчилсан сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Шинжлэх ухаан технологийн их сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан эмхтгэл болгон харьяа нэгжүүдийн нягтлан бодогч нарт хүргүүлж мөрддөг ба хамгийн сүүлд 2013 оны 1 сараас эхлэн шинэчилсэн хувилбарыг мөрдөн ажиллаж байна. Энэхүү бодлогын баримт бичиг нь УСННБОУС-тай нийцсэн байна. Олон Улсын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, салбар сургуулиуд дээрх нягтлан бодох бүртгэлийн програм нийцсэн байна.

Бид Шинжлэх ухаан технологийн их сургуулийн ашиглагдаж байгаа компьютерын системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Шинжлэх ухаан технологийн их сургууль нь өөрийн салбар сургуулиудын 2016 оны санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг өөрийн сургуулийн нягтлан бодогч, програмистуудын боловсруулсан E-FINANCE санхүүгийн программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

5. Материаллаг түвшин

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2016 оны санхүүгийн тайланд аудит гүйцэтгэхэд материаллаг түвшинг нийт зардлын дүнгээс 0.2 хувиар буюу 93,537.3 мянган төгрөгөөр тооцож төлөвлөсөн ба гүйцэтгэлийн үед материаллаг түвшинд өөрчлөлт ороогүй болно.

6. Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн дотоод хяналтын үйл ажиллагааг асуулга, ажиглалтын горимоор хянаж, санхүүгийн үйл ажиллагааны журам, санхүүгийн албадын бүтэц, зохион байгуулалтыг сайн гэж дүгнэсний үндсэн дээр хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед дунд гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хангалтгүй байна.

7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2016 оны урсгал болон тогтмол зардлуудыг сар, улирлын хуваарийн дагуу салбарын яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан бүрэлдэхүүн сургууль тус бүрд санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн төсвийн шууд захирагч нь 2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар улсын төвлөрсөн төсвөөс 2,035,393.3 мянган

төгрөгийн санхүүжилт авч, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 43,728,422.6 мянган төгрөгийн орлого олохоор төсөвлөсөн ч гүйцэтгэлээр улсын төвлөрсөн төсвөөс 3,751,192.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 43,376,701.7 мянган төгрөгийн орлого олжээ. Үүнээс урсгал зардалд 60,687,090.3 мянган төгрөг батлагдсанаас 44,420,195.3 мянган төгрөг зарцуулж 16,266,895.0 мянган төгрөгөөрдутуу зарцуулсан байна.

8. Шилэн дансны мэдээлэл

Шинжлэх ухаан технологийн их сургууль нь өөрийн <http://www.must.edu.mn/mn/> сайтад байгууллагынхаа шилэн дансны цэсийг байршуулсан ба 2014 оны 07 дугаар сарын 01-ны өдөр батлагдсан “Шилэн дансны тухай”, энэ хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актын хүрээнд сар бүрийн төсвийн гүйцэтгэл, 5 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээ болон эхний хасаг жилийн санхүүгийн тайлангийн мэдээллийг оруулсан байна.

9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу 54 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд 10 дансанд нийт 51 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Санхүү, сургалтын албан дахь сургалтын төлбөрийн үлдэгдэл зөрүүтэй, гэрээт ажлын хөлсийг шууд орлогод бүртгэсэн, нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварыг зөрүүтэй суутгасан, дотоод албан томилолтын зардлыг хэтрүүлэн олгосон, бараа материалыг аккруэл сууриар бүртгээгүй, үр ашиггүй зардал гаргасан, кассад орлогыг аваагүй, анхан шатны баримтын бүрдэлгүй гүйлгээ гаргасан зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, иж бүрэн байх, толилуулга ба тодруулга, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эдгээр эрсдэлүүд нь төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулах, орлого, зардлыг илүү, дутуу тооцох, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй байх сөрөг үр дагаварт хүрч болзошгүй байна.

10. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн төсвийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний бүх ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/ Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт ажил гүйлгээний 55,0 хувийг эзэлж байна.

11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Аудитын явцад төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлого, дансдын нэгдсэн жагсаалт, нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, төсөвт байгууллагын

санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлалын дагуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байдал, дансны болон ерөнхий журнал, ерөнхий дэвтэр зэрэг хураангуй бичилтийг арга зүйн хувьд нягтлан үзэж санхүүгийн тайлангийн илэрхийлэлд үнэлэлт өгсөн. Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Эрдэм шинжилгээний зардалд бүртгэгдсэн дараах томилолтын зардлууд нь төсвийн байгууллагын дагаж мөрдөх заавар журамтай зөрчилдөж байна. Үүнд: МехТС 612.0 мянган төгрөг, ГУУС 257.0 мянган төгрөг, ЭХС 8,730.0 мянган төгрөгийн томилолтын зардал илүү бодогдсон. УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга-д заасан "бие даасан байх зарчим"-ийн дагуу бүртгэлийн мэдээлэл нь хувь хүний үйл ажиллагааг биш, харин байгууллагын үйл ажиллагааг харуулж чадахаар зохион байгуулагдсан байх шаардлагатай. Иймээс байгууллагын дансаар орсон орлого нь тус байгууллагын үйл ажиллагааны орлого юм. Үүнтэй уялдан холбогдох зардал ч мөн адил байгууллагын мөрдвөл зохих журам зааварт нийцэж байх нь зүйтэй бөгөөд Сангийн Сайдын 2011 оны 132 дугаар тушаалыг дагаж мөрдөх шаардлагатай.

Шийдвэрлэсэн: Энэхүү асуудлыг холбогдох ажилтнуудад танилцуулж удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

2. ХШУС – ДЦС-4-тай байгуулсан гэрээгээр 40,630.2 мянган төгрөгийн төслийн урьдчилгаа санхүүжилт авах үед шууд орлогоор хүлээн зөвшөөрч эрдэм шинжилгээний гэрээт ажлын орлого дансанд бүртгэсэн байна. Энэ нь УСНББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга-д заасан "жинхэнэ хэрэгжилтийн зарчим"-ийн дагуу аливаа үйл явдлыг тохиолдсон үед нь бүртгэлд тусгана. Учир нь мөнгөөр төлөгдсөн эсэх, мөнгө хүлээн авсан эсэхээс нь үл хамааран ажил гүйлгээг гарсан тухай бүр нь орлого, зардлаар бүртгэнэ гэж заасныг зөрчсөн.

Шийдвэрлэсэн: Энэхүү асуудлыг холбогдох ажилтнуудад танилцуулж удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

3. МехТС - "Шим мандлаас атмосфер хүртэл өндөрт хүнгүй нисэх төхөөрөмжийн аэрозолийн судалгаа", "Ноос ноолууран бүтээгдэхүүн будах дижитал технологи", "3D CAD модель боловсруулах" эрдэм шинжилгээний төсөл хөтөлбөрүүдийн зардлыг хуваарилахдаа цалингийн сан болон ажил олгогчоос төлбөл зохих 11 хувийн нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг тусад нь хуваарилж байгаагүйгээс төслийн зардлын төсөвт тусгасан ажиллагсдад олгох цалингийн сангаас нийт 21 хувиар тооцон, нийгмийн даатгалын шимтгэлд 439.8 мянган төгрөг, хувь хүний орлогын албан татварт 136.9 мянган төгрөг, бүгд 576.7 мянган төгрөг илүү суутгаж татвар, нийгмийн даатгалын санд төвлөрүүлсэн /Эрдэм шинжилгээний ажлын зардалд бүртгэсэн/. Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйл "Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" үүрэгтэй гэж заасны зөрчсөн. Цалингийн сангаас зөвхөн даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийг суутган тооцно. Иймээс төсөл гэрээт ажлын төсвийг боловсруулахдаа ажил олгогчийн төлбөл зохих нийгмийн даатгалын шимтгэлийг цалингийн сангаас тусад нь төлөвлөх нь зүйтэй.

Шийдвэрлэсэн: Энэхүү асуудлыг холбогдох ажилтнуудад танилцуулж удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

4. ГУУС - 2016 оны 5 сарын 24-нд байгууллагын ажилтны эмчилгээнд зориулж 55 хүний цалингаас 2,530.4 мянган төгрөгийг цуглуулж өгөхдөө анхан шатны баримт, нотлох зүйлийг хавсаргаагүй, ажиллагсдын цалингийн карт хооронд шилжүүлэг хийсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн. Хамт олны хандив тусламжийг цалингийн цэсээр суутгал хийх эсвэл бэлэн мөнгө цуглуулах жагсаалт үйлдэн гарын үсэг цуглуулж, цалингийн картад хассан дүнгээр шилжүүлж болно.

Шийдвэрлэсэн: Энэхүү асуудлыг холбогдох ажилтнуудад танилцуулж удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

5. ГУУС - "Подстамын хамтарсан хээрийн шинжилгээ"-нд явсан жолоочийн ажлын хөлснөөс ХХОАТ 480.0 мянган төгрөг суутгасан боловч, татварын өглөг үүсгээгүй байна. МХТС - 10 оюутанд оюутны эрдэм шинжилгээний ажлын шагналаас ХХОАТ 71.0 мянган төгрөг суутгаж авсан боловч, 86.0 мянган төгрөгөөр ХХОАТ-ын өглөг үүсгэж бичсэн байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 26 дугаар зүйл 26.3 “Суутгагч нь албан татвар төлөгчийн орлогоос суутган авсан албан татварыг энэ хуулийн 26.1.6-д зааснаас бусад тохиолдолд дараа сарын 10-ны өдрийн дотор холбогдох төсөвт шилжүүлнэ.” гэсэн заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн: Энэхүү асуудлыг холбогдох ажилтнуудад танилцуулж удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

6. ХШУС - Бичиг хэргийн материал 4,716.1 мянган төгрөг, аж ахуйн материал 5,131.4 мянган төгрөг, сэлбэгийн 371.3 мянган төгрөг, хичээлийн зориулалттай материал 7,120.3 мянган төгрөг, барилгын материал болон сав баглаа боодол 104.1 мянган төгрөг, бусад материал 6,354.2 мянган төгрөг, бүгд 23,797.3 мянган төгрөгийн бараа материалыг өмнөх онд шаардах хуудсаар зарцуулсан боловч санхүүгийн тайланд тусгаагүй орхигдуулсан ба үүнийг бараа материалын данснаас зарлагадан, өмнөх үеийн үр дүнд бууруулах бичилт хийсэн байна. Энэ асуудал нь байгууллагын нярав бараа материалын зарцуулалтын тайланг бэлтгэхдээ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйл Нягтлан бодох бүртгэл хөтлөх заалтын дагуу гүйцэтгээгүй. Мөн ерөнхий нягтлан бодогч жилийн эцэст бараа материалын тооллогыг зохихзаавар журмын хүрээнд үнэн зөв, бодитой хэрэгжүүлээгүйгээс гарч байна. Эдгээр алдаа ньНББОУС 2 Бараа материал-д заасны дагуу худалдаж авсан үнийн дүнгээр орлогод авч зарцуулсан хэмжээгээр зарлагадах буюу аккрузл сууриар бүртгэх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.3 “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл

хөтөлж, санхүүгийн тайланг гаргах. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл 20.2.6 “Эд хөрөнгийн болон өр төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх ... үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн: Энэхүү асуудлыг холбогдох ажилтнуудад танилцуулж удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

7. БАС - Сургуулийн 2-р байрны гадна барилгыг тойруулж 27,732.1 мянган төгрөгөөр түр хашаа бариулсан боловч үндсэн хөрөнгөнд орлого аваагүй, авлагаар бүртгэсэн байна. Энэ нь НББОУС 16.16 “Хөрөнгийг анх олж эзэмших үед тухайн аж ахуйн нэгж нь буулгах, сэргээн засварлах, нүүлгэн шилжүүлэхтэй холбогдон гарсан зардлуудыг өөрөө хариуцахаар тооцоолсон бол эдгээр зардлууд өртөгт орно”, НББОУС 16.17 “Талбайг бэлтгэх зардал мөн өртөгт орно” гэж заасныг зөрчсөн.

Шийдвэрлэсэн: Энэхүү асуудлыг холбогдох ажилтнуудад танилцуулж удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

8. БАС - Барилгын дээвэр засварлуулах гэрээгээр 2015 онд 59,140.3 мянган төгрөг төлсөн бөгөөд, авлагаар бүртгэсэн. Энэ нь НББОУС 16.7 “Дараах шалгуурууд нэгэн зэрэг биелэгдсэн үед үндсэн хөрөнгөөр бүртгэнэ. Үүнд: а) аж ахуйн нэгжид ирээдүйн эдийн засгийн үр өгөөж авчрах боломжтой байх, б) хөрөнгийн өртгийг үнэн зөв хэмжих боломжтой байх” болсон үед үндсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрч бүртгэх ёстой байсныг зөрчсөн.

Шийдвэрлэсэн: Энэхүү асуудлыг холбогдох ажилтнуудад танилцуулж удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

9. ШУТИС ректорын 2013 оны А-104 тоот тушаалаар багш ажилчдын 180 айлын сууцны газар доорх В-1 давхрын 759.5 м.кв талбайг худалдан авах шийдвэр гарган нийт 1,379,237.0 мянган төгрөгийг төлсөн. Уг барилга баригдаж дууссан боловч, улсын комисс хүлээж аваагүйгээс үндсэн хөрөнгөөр бүртгэж авалгүй авлагаар бүртгэсэн байна. Уг авлагыг ҮТС-д 384,846.0 мянган төгрөг, ХШУС 200,240.0 мянган төгрөг, ЭХС 88,400.0 мянган төгрөг, БАС 225,750.0 мянган төгрөг, ГУУС 480,001.0 мянган төгрөгөөр тус тус бүртгэж байна. Төрийн болон орон нутгийн тухай хуулийн 11 дүгээр зүйл Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх 11.8 “Төрийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөнд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах санал, захиалгыг хянаж батлах, шинээр авах шийдвэр гаргах” заалтыг зөрчиж “Багш, ажилчдын байр”-ыг Төрийн өмчийн хорооны шийдвэргүйгээр барьсан байна.

Шийдвэрлэсэн: Энэхүү асуудлыг холбогдох ажилтнуудад танилцуулж удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

10. ГХИ - Русский мир байгууллагаас 4 удаагийн гүйлгээгээр 21,374.6 мянган төгрөг дансаар орсныг байгууллагад өгөх өглөгөөр бүртгээд, дэмжих баримтгүйгээр 21,308,6 мянган төгрөгийг Русский центрт зохион байгуулах хурлын зардалгэсэн гүйлгээний утгатай мөнгөн хөрөнгийн зарлагын баримтаар өглөгийг хаасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн: Энэхүү асуудлыг холбогдох ажилтнуудад танилцуулж удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

11. Эдийн засгийн бүх түвшинд хэмнэлтийн бодлого баримталж буй өнөө үед багш нарын баярын арга хэмжээнд 31,300.0 мянган төгрөг, сургуулийн сүлд дууны аранжировка хийлгэхэд 9,300.0 мянган төгрөг, хүлээн авалтын хоолны зардал 76,270.0 мянган төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” заалтыг зөрчсөн.

Шийдвэрлэсэн: Энэхүү асуудлыг холбогдох ажилтнуудад танилцуулж удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

12. ГУУС - Мөнгөний нярав 2016 оны 1 дүгээр улиралд 4 оюутны тушаасан 3,002.7 мянган төгрөгийг кассадорлого аваагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.6 “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.

Шийдвэрлэсэн: Энэхүү асуудлыг холбогдох ажилтнуудад танилцуулж холбогдох арга хэмжээ авч ажиллах талаар удирдлагад албан шаардлага хүргүүлэв.

13. Тайлант онд ШУТИС-ын дотоод аудитын алба, хөндлөнгийн 3 аудитын компанитай гэрээ байгуулж бүрэлдэхүүн сургуулиудын санхүүгийн алба болон сургалтын алба хоёрын хооронд үүсээд байсан он дамнасан дансны авлага, урьдчилж орсон орлого дансны зөрүүг оюутан тус бүрээр тулган 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн өмнөх үеийн үр дүнд залруулга хийсэн. Зөрүү үүссэн гол шалтгаан нь:

1. Оюутны кредит сонголт, сургалтын төлбөрийн тооцоог Санхүүгийн алба E-Finance програмаар, сургалтын алба UNIMIS програмаар бүртгэдэг, бөгөөд энэ хоёр програм нь хоорондоо холбогдоогүй байсан.

2. Сургалтын төлбөрийн тооцоо, төлөлтийг санхүүгийн алба, сургалтын алба хоёр тус тусдаа хийдэг ба харилцан мэдээлэл солилцох нэгдсэн журам тогтоогүй, өөр өөрсдийн шугамаар мэдээллээ олж авч гараар шивдэг. Кредит өөрчлөлт, сургалтын төлбөрийн төлөлтийн залруулга, багц кредитийн задралт, оюутны код солигдох, сургууль салах, нийлэх, оюутны шилжих хөдөлгөөн, мэргэжил, анги болон кредит салалтыг сургалтын алба, санхүүгийн алба ямар хугацаа цаглабараар хэрхэн мэдээлэл солилцох нэгдсэн

журам тогтоогоогүй. Мөн сургуулиас гарсан, шилжсэн оюутны мэдээлэл UNIMIS програмаас устдаг нь зөрүү үүсэх бас нэгэн шалтгаан болдог.

3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон тушаал шийдвэрээр оюутны сургалтын төлбөрийн авлага, гүйцэтгэлээр хичээл заагдаагүй үед оюутнаас төлсөн төлбөр буюу урьдчилж орсон орлого, оюутны төлбөрийг хүлээн зөвшөөрөх орлого зэрэг гурван данснуудад бичилт хийх журам арга зүйг журамлаж өгөөгүйгээс сургуулийн ахлах нягтлан бодогч бүр өөр өөрийн арга барилаар бүртгэж байгаа нь зөрүү үүсэх, байнга тооцоо нийлэх үндэс болсоор байна. Иймд дараах ажлуудыг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

- Сургалтын төлбөрийн тооцооллыг хоёр алба зэрэгцэн хийдэг одоогийн арга хэвшлийг өөрчилж, оюутны кредит сонголтоос эхлэн төлөх төлбөр, төлсөн дүн буюу урьдчилж орсон орлого, гүйцэтгэлээр хүлээн зөвшөөрөх орлогыг нь эх үүсвэрээс нь нэг урсгалаар мэдээлэл дамжуулдаг болгох. Үндсэн нэг програмаар оюутны дэлгэрэнгүй бүртгэлийг хөтлөх, програмын боловсруулалтыг сайжруулах. Уг бүртгэлийг хэрэв оюутны кодоор хийснээс мэдээлэл устдаг бол оюутны регистрийн дугаараар бүртгэлдээ хөтөлж болох юм.

- ШУТИС-ын удирдлагаас салбар сургуулиудын хэмжээнд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж мөрдүүлэх. Энэ бодлогын баримт бичигт оюутны сургалтын төлбөрийн хүлээгдэж буй гүйцэтгэл буюу төлөвлөгөө урьдчилж орсон орлого хүлээн зөвшөөрөх орлого, сургалтын төлбөрийн авлагыг дэлгэрэнгүй бүртгэл болон ерөнхий журналд оюутан бүрийн кодоор бүртгэх талаар жишээ загвар, зааварчилгаатай оруулж энэ дагуу програм хангамжаа сайжруулан зохицуулах.

- Цахимаар оюутан тус бүртэй сургалтын төлбөрийн тулган баталгаажуулалтыг хийдэг болох.

Дээрх шалтгааны улмаас ШУТИС-ын харьяа 11 сургууль дээр санхүү, сургалтын албаны авлага, урьдчилж орсон орлогын данс зөрсөн ба нийт 154,940.0 мянган төгрөгөөр ШУТИС-ийн нэгтгэсэн тайлангийн өмнөх үеийн үр дүнг нэмэгдүүлсэн байна.

Шийдвэрлэсэн: Энэхүү асуудлыг холбогдох ажилтнуудад танилцуулж удирдлагад зөвлөмж хүргүүлэв.

12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Материаллаг бус залруулагдаагүй алдаа байхгүй.

13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Байгууллагын орлого хүлээн зөвшөөрөх үүнтэй холбоотой урьдчилж орсон орлого, авлагын асуудлыг илүү боловсронгуй болгох шаардлагатай байна.

14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгөн шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,839,925.3 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 1,661,188.0 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч, 178,737.3 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг өмнөх оны үр дүнд Нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлт, залруулах бичилт хийсэн болно. Дээрх алдаа, зөрчлөөс Шинжлэх ухаан технологийн их сургуулийн хэмжээнд дотоод томилолтын зардал, нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвар, баримтын бүрдэл дутуу, үндсэн хөрөнгийг хүлээн зөвшөөрч бүртгээгүй, бараа материалын зарцуулалтыг аккрузал сууриар бүртгээгүй, кассад орлого аваагүй зэрэг хэв шинжийн хувьд материаллаг гэж үзэж болохуйц 158,615.80 мянган төгрөгийн алдаа, зөрчил гарсан байна. Энэ нь төлөвлөлт болон гүйцэтгэлийн үе шатан дахь материаллаг түвшингийн хэмжээс 65,078.50 мянган төгрөгөөр хэтэрсэн байна.

16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төсвийн захирагчийн 2015 оны тайланд “СМД” Аудит ХХК хийж нийт 2 зөвлөмж өгсөн бөгөөд эдгээр зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

17. Хязгаарлалттай санал дүгнэлт

Төсөл, хөтөлбөртэй холбоотой дотоод томилолтын зардлыг илүү тооцсон, урьдчилж орсон орлогыг эрдэм шинжилгээний орлогоор шууд хүлээн зөвшөөрсөн, бараа материалын тооллогыг үнэн зөв, зохих журмын дагуу гүйцэтгээгүй, үндсэн хөрөнгийг орлогод аваагүй, авлагаар бүртгэсэн, анхан шатны баримтгүй гүйлгээ хийсэн, кассад орлого аваагүй зэргийг эс тооцвол Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн Сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.



ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Тэргүүлэх ач холбогдол № 1

Асуудал 1: Орлого15

Асуудал 2: Зардал16

Тэргүүлэх ач холбогдол № 2

Асуудал 3: Бараа материал17

Асуудал 4: Кассын орлого18

Тэргүүлэх ач холбогдол № 3

Асуудал 5: Үндсэн хөрөнгө18

Асуудал 6: НДШ, ХХОАТ19

2017оны03 дугаар сар10

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Аудитын газар нь аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд хяналтын сул тал буюу горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Тиймээс зөвлөмжүүд маань дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний ойлголтыг тусгасан. Эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд харин эдгээр зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитыг хэрэгжүүлэх явцад дараах горимуудыг хэрэгжүүлсэн. Үүнд:

- Санхүүгийн тайлангийн бүртгэл хөтлөлт, дотоод хяналтын системийг судлах
- Санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлт, дотоод хяналтын үйл ажиллагааг тодорхойлж, эрсдэлийг үнэлэх
- Санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэл хөтлөлт, журналаас ажил гүйлгээг хөөн шалгаж үлдэгдлийг тохируулах

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Шинжлэх ухаан технологийн их сургуулийн санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдагдсан зүйлсийг ач холбогдлынх нь дарааллаар дурдвал:

Асуудал – 1: Орлого	Тэргүүлэх ач холбогдол №1
---------------------	---------------------------

Ажиглалт:

➤ 2016 онд тус сургуулийн дотоод аудитын албанаас санхүү, сургалтын албаны сургалтын төлбөрийн авлага болон урьдчилж орсон орлогын үлдэгдэл зөрөөд байгаатай холбоотой Конфиденс аудит ХХК, Баян Сагсай аудит ХХК, Эс Жи Эм Ди Аудит ХХК-тай гэрээ байгуулж тулган баталгаажуулалт хийлгэсэн. Дээрх зөрүү үүссэн үндсэн шалтгаан нь:

1. Оюутны кредит сонголт, сургалтын төлбөрийн тооцоог Санхүүгийн алба E-Finance програмаар, сургалтын алба UNIMIS програмаар бүртгэдэг, бөгөөд энэ хоёр програм нь хоорондоо холбогдоогүй байсан.

2. Сургалтын төлбөрийн тооцоо, төлөлтийг санхүүгийн алба, сургалтын алба хоёр тус тусдаа хийдэг ба харилцан мэдээлэл солилцох нэгдсэн журам тогтоогүй, өөр өөрсдийн шугамаар мэдээллээ олж авч гараар шивдэг. Кредит өөрчлөлт, сургалтын төлбөрийн төлөлтийн залруулга, багц кредитийн задралт, оюутны код солигдох, сургууль салах, нийлэх, оюутны шилжих хөдөлгөөн, мэргэжил, анги болон кредит салалтыг сургалтын алба, санхүүгийн алба ямар хугацаа цаглабараар хэрхэн мэдээлэл солилцох нэгдсэн журам тогтоогоогүй. Мөн сургуулиас гарсан, шилжсэн оюутны мэдээлэл UNIMIS програмаас устдаг нь зөрүү үүсэх бас нэгэн шалтгаан болдог.

3. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон тушаал шийдвэрээр оюутны сургалтын төлбөрийн авлага, гүйцэтгэлээр хичээл заагдаагүй үед оюутнаас төлсөн төлбөр буюу урьдчилж орсон орлого, оюутны төлбөрийг хүлээн зөвшөөрөх орлого зэрэг гурван данснуудад бичилт хийх журам арга зүйг журамлаж өгөөгүйгээс сургуулийн ахлах нягтлан бодогч бүр өөр өөрийн арга барилаар бүртгэж байгаа нь зөрүү үүсэх, байнга тооцоо нийлэх үндэс болсоор байна.

Дээрх шалтгааны улмаас ШУТИС-ын харьяа 11 сургууль дээр санхүү, сургалтын албаны авлага, урьдчилж орсон орлогын данс зөрсөн

Зөвлөмж:

✓ Сургалтын төлбөрийн тооцооллыг хоёр алба зэрэгцэн хийдэг одоогийн арга хэвшлийг өөрчилж, оюутны кредит сонголтоос эхлэн төлөх төлбөр, төлсөн дүн буюу урьдчилж орсон орлого, гүйцэтгэлээр хүлээн зөвшөөрөх орлогыг нь эх үүсвэрээс нь нэг урсгалаар мэдээлэл дамжуулдаг болгох. Үндсэн нэг програмаар оюутны дэлгэрэнгүй бүртгэлийг хөтлөх, програмын боловсруулалтыг сайжруулах. Уг бүртгэлийг хэрэв оюутны кодоор хийснээс мэдээлэл устдаг бол оюутны регистрийн дугаараар бүртгэлдээ хөтөлж болох юм;

✓ ШУТИС-ын удирдлагаас салбар сургуулиудын хэмжээнд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулж мөрдүүлэх. Энэ бодлогын баримт бичигт оюутны сургалтын төлбөрийн хүлээгдэж буй гүйцэтгэл буюу төлөвлөгөө урьдчилж орсон орлого хүлээн зөвшөөрөх орлого, сургалтын төлбөрийн авлагыг дэлгэрэнгүй бүртгэл болон ерөнхий журналд оюутан бүрийн кодоор бүртгэх талаар жишээ загвар, зааварчилгаатай оруулж энэ дагуу програм хангамжаа сайжруулан зохицуулах;

